



ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ



# СҮРЬЕЭГҮЙ ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ **ХАМТДАА**



*Эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилсөн  
хүмүүсийн гэр бүлд зориулсан өврийн лавлах*

Улаанбаатар хот





ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ



# СҮРЬЕЭГҮЙ ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА



*Эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн  
гэр бүлд зориулсан өврийн лавлах*

Улаанбаатар хот

# СҮРЬЕЭГҮЙ ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

Эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн  
гэр бүлд зориулсан өврийн лавлах

Эхийг боловсруулсан: Д.Наранзул  
Хүний их эмч, Анагаах ухааны доктор

Хянасан: Д.Доржмаа  
Хүний их эмч, Анагаах ухааны магистр



## ТАНАЙ ГЭР БҮЛИЙН ХҮМҮҮСИЙН ЭРҮҮЛ МЭНД ЯМАР БАЙНА ВЭ?

**Та бүхэн халдвар авсан байж магадгүй .....** Танай гэр бүлийн хэн нэгэн эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилсөн бол та бүхэн халдвар авсан байж магадгүй. Учир нь цэрэнд сүрьеэгийн нян илэрч байгаа үед бусдад халдвар тараах эрсдэлтэй байдаг.

**Гэр бүлийнхээ эрүүл мэндийн үзлэгээс эхэлцгээе.** Сүрьеэгийн эм ууж эхлэхэд ханиалга багасаж, цэртэй хамт ялгарах нянгийн тоо хэмжээ буурдаг. Харин сүрьеэгийн халдвар тараах хамгийн эрсдэлтэй үе нь онош тогтоож, сүрьеэгийн эм уухаас өмнөх үед байдаг. Иймээс ханиалгаж эхэлсэн үеэ санаж, энэ хугацаанд ойр байсан бүх хүмүүсийг эрүүл мэндийн үзлэг хийлгэх хэрэгтэй. Юуны өмнө гэр бүлийн хүмүүсийг үзлэгт хамруулах ёстой.

**Эрүүл мэндийн үзлэг:** Эрүүл мэндийн үзлэгийг харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерт үнэ төлбөргүй хийлгэнэ. Хэрэв хөдөө орон нутагт амьдардаг бол сум, өрхийн эрүүл мэндийн төвд үзлэгт хамрагдаж болно. Цаашид нарийвчилсан шинжилгээ шаардлагатай бол эмч нар энэ талаар зөвлөгөө өгнө.

**Цээжний гэрлийн шинжилгээ:** Сүрьеэгээр өвчилсөн байна уу? Ялангуяа таны уушгинд ямар нэг өөрчлөлт байна уу? гэдгийг цээжний рентген зураг авч шалгана.

**Туберкулины арьсны сорил:** Танай гэр бүлийн 0-15 насны хүүхдэд туберкулины арьсаны сорил тавьж сүрьеэгийн халдвар авсан байна уу? гэдгийг илрүүлнэ.

**Цэрний шинжилгээ:** Дээрх үзлэг, шинжилгээний явцад шаардлагатай бол цэрний 2 удаагийн сорьц авч холбогдох шинжилгээг хийж, таны оношийг тодруулна.

Сүрьеэгийн эмчилгээ, эрүүл мэндийн үзлэгийн зардлыг улсаас гаргадаг. Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер болон сум, өрхийн эрүүл мэндийн төв нь сүрьеэгийн урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ, эрүүл мэндийн талаар зөвлөгөө өгөх газар юм. Хэрэв танай гэр бүлд санаа зовоосон асуудал байгаа бол эдгээр газарт хандаж зөвлөгөө авах хэрэгтэй.

Мөн энэ өврийн лавлахыг арын нүүрэнд эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан эсэхийг тэмдэглэх хүснэгтийг дагалдуулан хүргэж байна. Танай гэр бүлд эрүүл энхийг хүсье.

Д.Наранзул, Анагаах ухааны доктор

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн

Халдварт өвчний тандалт сэргийлэлт эрхэлсэн дэд захирал

## ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭ ӨВЧНИЙ ТУХАЙ

Сүрьеэгийн эсрэг эмийг эмчийн зааврын дагуу тохирсон тун хэмжээгээр уухгүй бол сүрьеэгийн нян эмүүдэд тэсвэртэй болно. Энэ нь сүрьеэгийн эсрэг эмүүд нянг устгаж чадахгүй боллоо гэсэн үг юм.

### Эмэнд тэсвэртэй сүрьеэ ямар хүмүүст тохиолдох эрсдэлтэй вэ?

- Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй хүнтэй хамт байсан
- Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний гэр бүлийн болон ойрын хавьтал
- Сүрьеэгийн эсрэг эмийг өдөр бүр тогтмол тууштай уухгүй байх
- Эмийг эмчийн өгсөн тун заавраар хэрэглэхгүй байх
- Өмнө нь сүрьеэгээр өвчилж байсан ба эмчилгээг бүрэн төгс хийлгээгүй
- Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн өвчлөл өндөртэй газарт ажиллаж амьдрах



## СҮРЬЕЭГИЙН НЯН ЭМЭНД ТЭСВЭРЖИХ ШАЛТГААН ЮУ ВЭ ?

Эмэнд тэсвэртэй сүрьеэг хүн өөрөө үүсгэдэг. Үүний гол шалтгаан нь:

- Сүрьеэгийн эсрэг эмчилгээг хяналтгүй хийлгэх
- Сүрьеэгийн эмийг зүй бусаар хэрэглэх
- Сүрьеэгийн эмчилгээг дутуу хийлгэх, таслах
- Чанаргүй эм хэрэглэх
- Эмч, сувилагчийн өгсөн заавар зөвлөмжийг бүрэн дагаж мөрдөхгүй байх
- Эдгээр шалтгааны улмаас та болон танай гэр бүлийн гишүүн эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилж болно.



## ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭ ХЭР АЮУЛТАЙ ВЭ?

### Нас баралт:

Эрт оношлуулж, эмчилгээг бүрэн хийлгээгүй тохиолдолд үхэлд хүргэдэг.

### Өвчлөл:

Өвчний явц удааширч, гэр бүл, найз нөхөд, нийгэм хамт олонд эмэнд тэсвэртэй сүрьеэгийн нян халдварлуулан өвчлүүлдэг.

### Зардал ихтэй:

- Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээ өндөр үнэтэй
- Эмчилгээний үргэлжлэх хугацаа урт 9-24 сар
- Зарим хүнд эмийн гаж нөлөө илэрч болно
- Удаан хугацаагаар эмнэлэгт хэвтэх, хөдөлмөрийн чадвар алдсанаас өрхийн орлого буурдаг.

### 1 өвчтөнг эмчлэхэд гардаг шууд зардал:

Өвчтөний эмийн тэсвэржилтийн хэлбэрээс хамаараад эмчилгээнд 10-40 гаруй сая төгрөг зарцуулдаг. Энэ зардлыг Монгол улсын Засгийн газар болон олон улсын хандив тусламжийн санхүүжилтээс гаргадаг.



## ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭ ХЭРХЭН ХАЛДВАРЛАДАГ ВЭ?

Амьсгалын зам нь сүрьеэ өвчин тархах гол зам юм. Эмэнд тэсвэртэй сүрьеэ ч адилхан амьсгалын замаар хүнээс хүнд халдварладаг.

- Уушгины сүрьеэтэй өвчтөн ярих, дуулах, хашгирах, найтаах ялангуяа ханиалгахад сүрьеэгийн нян агуулсан маш жижиг, олон арван дуслыг агаарт цацдаг.
- Уушгины сүрьеэтэй өвчтөн ханиах (3500 ширхэг) болон найтаахад (1 сая ширхэг) их хэмжээний савханцар агуулсан дуслууд богино хугацаанд агаарт цацагдаж тэдгээр нь уурших хүртлээ хөвж байдаг.
- Ханиалгахад 5 минут чанга ярихад ялгарахтай тэнцүү тооны нян агуулсан жижиг дуслууд агаарт цацагддаг.
- Бохирлогдсон агаараар эрүүл хүн амьсгалж халдвар авч өвчилдөг.

## ТАНАЙ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮН СҮРЬЕЭГЭЭР ӨВЧИЛСӨН ҮЕД ХЭН ХАЛДВАРТ ӨРТӨХ ЭРСДЭЛТЭЙ ВЭ?

Эмэнд тэсвэртэй сүрьеэгээр хэн ч өвчилж болно. Гэхдээ энэ нь халдвартай, халдваргүй хэлбэрийн сүрьеэтэй өвчтөний хувьд өөр өөр байдаг.



### Уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөний хувьд

- Өвчтөний гэр бүлийн гишүүд халдвар авах эрсдэл -100%
- Хамаатан садан, найз нөхөд, хамт ажиллагсад -10%
- Холын хавьтал -1% нь халдвар авах эрсдэлтэй байдаг
- Мөн ХДХВ-ийн халдвартай, чихрийн шижин, хорт хавдар, химийн эмчилгээ хийлгэж байгаа хүмүүс болон ходоод, гэдэс тайруулах мэс засал хийлгэсэн хүмүүс өвчлөх эрсдэл өндөр байдаг.

### Анхааруулга:



Гэр бүлийн гишүүд халдвар авах, өвчлөх эрсдэл хамгийн өндөр тул танай гэр бүлийн бүх гишүүд эмчийн зааврын дагуу үзлэг, шинжилгээнд тогтмол хамрагдаж байх ёстой.

## ХАЛДВАР АВСАН ХҮН БҮР ӨВЧЛӨХ ҮҮ ?

- Халдвар авсан хүмүүсийн 10 орчим хувь нь өвчилж ихэнх нь амьдралынхаа туршид сүрьеэгийн халдварыг хадгалсаар явдаг.
- Ихэнх тохиолдолд халдвар авсан хүний дархлаалын тогтолцоо сүрьеэгийн нянгийн эсрэг тэмцэж үржлийг зогсоодог.
- Ингэснээр нян бүрмөсөн устахгүй ч биед хор хөнөөл учруулж чадахгүй идэвхгүй байдалд ордог.
- Гэхдээ хэзээ нэгэн цагт идэвхжиж өвчин үүсгэж болно.
- Сүрьеэ өвчин нь халдвар авснаас хойш 2-3 сараас хэдэн жилийн дараа ч үүсч болно.



## СҮРЬЕЭГЭЭР ӨВЧИЛСӨН ҮЕД ЯМАР ШИНЖ ТЭМДЭГ ИЛРЭХ ВЭ?

Хэрэв танд доорх шинж тэмдгүүдээс аль нэг нь илэрвэл харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерт очиж үзүүлэн зөвлөгөө авах шаардлагатай. Сүрьеэ өвчний үед илрэх шинж тэмдэг нь сүрьеэгийн нян бие махбодийн аль эрхтэнд байрласнаас шалтгаалан эмнэлзүйн шинж тэмдэг илэрдэг.

**Уушгины сүрьеэгийн үед:** Ханиалгах нь уушгины сүрьеэгийн хамгийн түгээмэл шинж тэмдэг юм.

- 2 долоо хоногоос дээш хугацаагаар ханиалгах
- Цээжээр өвдөх
- Цэр гарах
- Амьсгаадах



**Нэмэлт мэдээлэл:** Энэ нь уушгинд эмгэг өөрчлөлт үүсэж байгааг харуулж байгаа бөгөөд үүний шалтгаан нь сүрьеэ байж магадгүй тул та эмчид яаралтай хандах хэрэгтэй.

**Сүрьеэ өвчний үед илрэх бусад шинж тэмдэг:**

- Ядрах. Ямар нэг биеийн хүчний ажил, ачаалалтай холбоогүйгээр ядрах, сульдах нь олон хоногоор үргэлжилбэл аливаа нэг өвчний шинж тэмдэг гэж ойлгож болно. Иймээс та эмчид яаралтай хандах хэрэгтэй.

**Сүрьеэ өвчний үед илрэх бусад шинж тэмдэг:**

- Турах. Сүрьеэ өвчний үед ердийн иддэг хоол хүнсээ тогтмол хэрэглэж байсан ч турах, биеийн жин буурах шинж илэрдэг. Турж байна гэдэг нь өвчин идэвхжиж байгаагийн шинж юм. Иймээс эмчид яаралтай хандах хэрэгтэй.

**Сүрьеэ өвчний үед илрэх бусад шинж тэмдэг:**

- Хоолонд дургүй болох
- Халуурах

Та шалтгаангүйгээр халуурах буюу таны бие сульдаж тавгүй болох шинж тэмдэг хэд хоног үргэлжилвэл эмчид хандаж үзлэг, шинжилгээ хийлгээрэй.

**Сүрьеэ өвчний үед илрэх бусад шинж тэмдэг:**

- Шөнө хөлрөх

Шөнө унтаж байхдаа шалтгаангүй хөлрөх шинж тэмдэг илэрвэл эмчид яаралтай хандах хэрэгтэй.

## УУШГИНААС БУСАД ЭРХТЭНИЙГ ГЭМТЭЭСЭН ҮЕД ЯМАР ШИНЖ ТЭМДЭГ ИЛРЭХ ВЭ?

Уушгины бус эрхтэний сүрьеэгийн үед сүрьеэгийн нян ямар эрхтэнд эмгэг өөрчлөлт үүсгэсэн түүнтэй холбоотойгоор доорх шинж тэмдэг илэрнэ.



### Булчирхайн сүрьеэ:

- Булчирхай томорч, тэмтрэхэд өвчингүй, хүйтэн.
- Эхний үед хатуу, сүүлдээ зөөлөрч цоорч болно



### Яс үений сүрьеэ:

- Хөдөлгөөн хязгаарлагдсан, өвчинтэй, хавдана
- Хожуу үед цоорч болно



### Сүрьеэгийн менингит:

- Толгойн өвдөлт аажим эхэлнэ. Халуурна, хүзүү хөшинө, ухаан балартана, татна. Өвчтөн унтаа, сул байдалтай байна.



### Хэвлийн сүрьеэ

- Хэвлий томорно, хөндүүртэй, халуурна, суулгана, өтгөн хатна, хэвлийд хатуу зүйл тэмтрэгдэнэ.



### Залгиур хоолойн сүрьеэ

- Хоолой сөөнө, хөндүүрлэнэ
- Бусад шинж тэмдэг илэрч болно



### Шээс боловсруулах, бэлэг эрхтний сүрьеэ

- Шээс олшрох, цустай шээх, бүсэлхийгээр өвдөнө.
- Эмэгтэйчүүд үргүйдэлт хүрч болзошгүй

## ТАНАЙ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮН ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭГЭЭР ӨВЧИЛСӨН ТОХИОЛДОЛД ТА ЮУ ХИЙХ ВЭ?

- Танай гэр бүлийн хэн нэгэн эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилсөн нь лабораторийн шинжилгээгээр батлагдсан үед яаралтай эмчилгээнд хамруулах
- Сүрьеэгээр өвчилсөн хүн эрт эмчилгээнд хамрагдана төдий чинээ халдвар ялгаруулалт (бусдад халдвар тараах) эрт үгүй болж бүрэн эдгэрнэ.
- Та өөрийн харъяа аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерт хандаж эмчилгээнд хамрагдах асуудлыг шийдвэрлүүлэх
- Сэтгэл санаагаар дэмжих, эмчлүүлэх, эдгэрэх итгэл найдвар төрүүлэх
- Эмчилгээ удаан хугацаагаар үргэлжлэх тул ажил, хичээл, сургуулийг зохицуулах
- Гэр бүлийн бүх гишүүдийг харъяа сүрьеэгийн диспансер, сум, өрхийн эрүүл мэндийн төвд үзлэг шинжилгээнд бүрэн хамруулах

### Анхааруулга:

**!** Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний эмчилгээний асуудлыг эмч нарын хамтарсан зөвлөгөөнөөр шийдвэрлэдэг. Өвчтөний эмчилгээг анх эхлэх үед гэр бүлийн асран хамгаалагч, өвчтөн, эмч нарын дунд гурвалсан гэрээ байгуулдаг. Ийм учраас танай гэр бүлийн хэн нэгэн эмч нарын хамтарсан зөвлөгөөнд өвчтөнийг орох үед хамт ирэх ёстой.

## СҮРЬЕЭТЭЙ ХҮНД АСАРГАА, СУВИЛГАА ХЭРХЭН ХИЙХ ТУХАЙ

Эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилсөн хүн 9-24 сар эмчилгээ хийлгэхээс гадна зарим өвчтөнд эмийн гаж нөлөө илэрдэг. Үүний зэрэгцээ удаан хугацаагаар эмчилгээ хийлгэдэгтэй холбоотой ажил, хичээлээс чөлөөлөгдөх, хамт олон найз нөхдөөсөө хөндийрэх нь тэдэнд бас сэтгэл санааны таагүй байдал үүсгэдэг. Ийм үед найз нөхдийн дэмжлэг, гэр бүлийн хайр халамж асаргаа сувилгаа хамгийн чухал байдаг.





**Та гэр бүлийнхээ хүнд дараах байдлаар туслах хэрэгтэй**

- Гэр бүлийн хүнтэйгээ дотно ярилцах, түүнийг сонсох
- Эдгэрэх итгэл найдвар төрүүлэх
- Эмчилгээг өдөр бүр хийлгэх боломжийг бүрдүүлэх
- Эмээ уухад нь байнга туслах (эмнэлэгт хамт очих, унааны мөнгөөр туслах гэх мэт....)
- Эмчилгээг өдөр бүр хийлгэж байгаа эсэхэд хяналт тавьж байх
- Эмчилгээний явцад ямар зовиур шаналгаа гарч байгааг анхаарч асууж байх
- Эмчилгээний хяналтын шинжилгээг хугацаандаа өгч байгаа эсэх, шинжилгээний хариу ямар гарч байгаа зэргийг мэдэж байх
- Эмнэлэгт хэвтэж байх хугацаанд сайхан хоол, сэтгэлийн бэлэг илгээж байх
- Илчлэг сайтай чанартай хоол, хүнсийг тогтмол хэрэглүүлэх
- Эрүүл агаарт хамт алхах, зугаалах

**Анхааруулга:**

Сүрьеэтэй хүн өвчин шаналал, хүнд бэрхийг даван туулахад гэр бүл, хамаатан садан, найз нөхдийн тусламж, хамт олны дэмжлэг, хайр халамж хамгийн үнэтэй зүйл юм.

## АЖИЛ, АМРАЛТАА ЗОХИЦУУЛАХАД ХЭРХЭН ТУСЛАХ ВЭ?

Эмэнд тэсвэртэй сүрьеэ нь хүний бие махбодь, сэтгэл санааг маш их ядаргаанд оруулдаг. Өвчтөн цаг үргэлж өвчинтэйгээ тэмцэж байдаг учир ажил хийж амжуулах нь бараг боломжгүй байдаг.

**Та амралт, ажлаа зохицуулахад нь дараах байдлаар туслаарай**

- Сүрьеэгээр өвчилсөн хүмүүс эхний 2-3 сард сайн амрах ёстой
- Сайн амарч унтах, сэтгэл санаа тайван байх тусам таны дархлаа сэргэж хурдан эдгэрэх боломж бүрдэнэ.
- Зарим хүмүүс бие нь бага зэрэг сайжирч зовиур шаналгаа багасгах үед ажил, хичээлдээ орохыг яаравчилдаг энэ нь зөв сонголт биш юм
- Эмчилгээ дуустал ажил, хичээлдээ явахгүй байх нь хамгийн зөв сонголт бөгөөд энэ үед гэр бүлийн дэмжлэг хамгийн чухал байдаг.

**Анхааруулга:**

Хэрэв таны гэр бүлийн хүний бие бүрэн тэнхрээгүй байхад хүнд хүчир ажил хийвэл өвчин дахин сэдэрч, эмчилгээний үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.



## ТА ГЭР БҮЛИЙН ХҮНДЭЭ ЭМЧИЛГЭЭ ХИЙЛГЭХЭД НЬ ХЭРХЭН ТУСЛАХ ВЭ?

Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эсрэг эмийг удаан хугацаагаар ууж, тариа тариулдаг тул өвчтөн болон гэр бүлийн гишүүдээс ихээхэн хүчин чармайлт, хамтын зүтгэл гарч байж эмчилгээний үр дүн гардаг.



## ТА ГЭР БҮЛИЙН ХҮНЭЭ ЭМНЭЛЭГТ ЭРГЭЖ ОЧИХДОО ЮУ АНХААРАХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Таны ойр дотны хэн нэгэн эмнэлэгт хэвтсэн үед сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх нь туйлын чухал юм. Харин таны эргэлт эмчилгээний зарчим, эмнэлгийн журамд нийцсэн байх ёстой юм шүү.



### Эргэлтээр очихдоо өгч болох зүйлс:

- Эргэлтийн цагаар эмчилгээний дэглэмд нийцсэн хоол
- Жимс, ногоо, чихэр, печень
- Сүү, тараг, цагаан идээ
- Ногоон цай болон жимсний шүүс
- Цэцэг
- Унших ном, сонин, сэтгүүл гэх мэт

### Хориглох зүйл:

- Архи, согтууруулах төрлийн ундаа
- Их хэмжээний мөнгө, үнэт эдлэл
- Эмчилгээний дэглэм зөрчихөөр өөх, тос, давс ихтэй хоол
- Харшил өгөхүйц үнэртэй, тоос, тоосонцортой цэцэг



### Анхааруулга:



Сүрьеэ нь амьсгалын замаар халдварладаг тул бага насны хүүхдийг онцын шаардлагагүй бол эргэлтээр очихдоо дагуулж явахгүй байх хэрэгтэй. Та ч мөн өөрийгөө халдвараас хамгаалах талаар анхаарах хэрэгтэй.

## ГЭР БҮЛИЙН ГИШҮҮД ХАВЬТЛЫН ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНД ХЭРХЭН ХАМРАГДАХ ТАЛААР

### Танай гэр бүл дараах зааврыг заавал мөрдөнө

- Танай гэр бүлийн гишүүд 3 жилийн турш харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн хяналтанд байна.
- Эмчийн зааврын дагуу 6 сар тутамд 1 удаа үзлэгт хамрагдаж байх ёстой.
- Та бүхэн дараах үзлэг, шинжилгээнд хамрагдана. Үүнд:
- Танай гэр бүлийн 0-5 хүртлэх насны хүүхдэд туберкулины арьсны сорил тавьж сүрьеэгийн халдвар авсан эсэхийг тодруулна.
- Бусад гэр бүлийн бүх гишүүд цээжний гэрлийн шинжилгээнд хамрагдана.
- Хэрэв танай гэр бүлийн хэн нэгэнд 14 хоногоос дээш хугацаагаар ханиалгах, цэр гарах зэрэг шинж тэмдэг илэрч байвал цэрний шинжилгээ заавал өгнө.
- Хэрэв танай гэр бүлийн гишүүдийн хэн нэгэнд ямар нэг зовиур шаналгаа илэрсэн үед цаг алдалгүй харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер, өрх, сумын эмнэлэгт хандаж зөвлөгөө авах хэрэгтэй.

### Анхааруулга:

**!** Танай гэр бүлийн бүх гишүүд эмчийн зааврын дагуу тогтоосон хугацаанд үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдаж байх нь нэн чухал. Энэ нь танай гэр бүлийн гишүүдийн хэн нэгэн сүрьеэгээр өвчилсөн үед эрт илрүүлэх, гэр бүл доторх халдварын тархалтыг таслан зогсоох, эмчилгээнд эрт хамруулах, бүрэн төгс эдгэрэхэд чухал ач холбогдолтой юм.



## ГЭРИЙН НӨХЦӨЛД БАРИМТЛАХ ДЭГЛЭМ

Танай гэр бүлийн гишүүн эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилсөн бол эмчилгээг бүрэн хийлгэх нь бусдад халдвар тараахгүй байх цорын ганц боломж юм. Хэрэв танай гэр бүлийн гишүүн ямар нэг шалтгааны улмаас эмнэлэгт хэвтээгүй сүрьеэгийн диспансер, өдрийн эмчилгээний цэгээр эрчимт шатны эмчилгээ хийлгэж байгаа бол дараах зааврыг дагана уу.



### Та дараах зааврыг заавал мөрдөнө

- Эмчилгээний хугацаанд эмч, сувилагчийн хяналтанд өдөр бүр эмээ тасралтгүй тууштай уух
- Ярих, инээх, ханиах, найтаах үед ам хамраа амны цаасаар таглах, дараа амны цаасаа аль болох хурдан устгах
- Цэрний түрхэц, өсгөврийн шинжилгээ сөрөг болтол ажил, хичээлдээ явахгүй байх
- Гэр бүлийн гишүүдээс тусдаа өрөөнд унтаж байх
- Та гэрт амьдардаг бол хаалга, тоононы салхивчийг онгойлгож өдөрт 4-5 удаа 15-20 минут агаар оруулах
- Та байшинд амьдардаг бол өрөө, тасалгааны цонхийг онгойлгож өдөрт 4-5 удаа 15-20 минут агаар оруулах
- Гэр, байшиндаа нарын гэрэл сайн оруулж байх
- Сүрьеэгийн халдвар нь агаараар дамждаг гэдгийг байнга санаж байх

### Анхааруулга:



Та эмчийн заавар, зөвлөмжийн дагуу эмчилгээ хийлгэж эмээ тасралтгүй тууштай ууж байгаа бол хэдхэн сарын дараа халдвар ялгаруулахаа (бусдад халдвар тараахаа) болино.

Та ойр дотны хүмүүсээ ялангуяа гэр бүлийн гишүүдээ халдвар авсан, өвчилсөн эсэхийг мэдэхийн тулд амьдарч байгаа аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер болон сум, өрхийн эмнэлэгт очиж үзлэг шинжилгээнд хамруулах хэрэгтэй.

Сүрьеэгийн халдвар дамжих эрсдэл гэр бүлийн хүрээнд 100%, найзуудын хүрээнд 10% байдаг. Сүрьеэгийн халдварт хүүхэд, өндөр настан, дархлаа султай хүмүүс илүү өртөх магадлалтай байдаг.



Үйлчлүүлэгчийн

Овог:..... Нэр:..... Нас:..... Хүйс:.....

Гэрийн хаяг:.....

.....

Ажил, сургуулийн хаяг:.....

.....

Ам бүлийн тоо:.....

## ХАВЬТЛЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН ТЭМДЭГЛЭЛ

| Үзүүлэлт              | ..... он..... сар..... өдөр | ..... он... сар.... өдөр |
|-----------------------|-----------------------------|--------------------------|
| Туберкулины сорил     |                             |                          |
| Цээжний рентген зураг |                             |                          |
| Цэрний шинжилгээ      |                             |                          |
| Бусад                 |                             |                          |

| Үзүүлэлт              | ..... он..... сар..... өдөр | ..... он... сар.... өдөр |
|-----------------------|-----------------------------|--------------------------|
| Туберкулины сорил     |                             |                          |
| Цээжний рентген зураг |                             |                          |
| Цэрний шинжилгээ      |                             |                          |
| Бусад                 |                             |                          |



| Үзүүлэлт              | ..... он..... сар..... өдөр | ..... он... сар.... өдөр |
|-----------------------|-----------------------------|--------------------------|
| Туберкулины сорил     |                             |                          |
| Цээжний рентген зураг |                             |                          |
| Цэрний шинжилгээ      |                             |                          |
| Бусад                 |                             |                          |

| Үзүүлэлт              | ..... он..... сар..... өдөр | ..... он... сар.... өдөр |
|-----------------------|-----------------------------|--------------------------|
| Туберкулины сорил     |                             |                          |
| Цээжний рентген зураг |                             |                          |
| Цэрний шинжилгээ      |                             |                          |
| Бусад                 |                             |                          |

| Үзүүлэлт              | ..... он..... сар..... өдөр | ..... он... сар.... өдөр |
|-----------------------|-----------------------------|--------------------------|
| Туберкулины сорил     |                             |                          |
| Цээжний рентген зураг |                             |                          |
| Цэрний шинжилгээ      |                             |                          |
| Бусад                 |                             |                          |

**Тайлбар:** Та харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер болон өрх, сумын эрүүл мэндийн төвд үзүүлсний дараа энэхүү хэсэгт тэмдэглэх хэрэгтэй.

Танай гэр бүлийн хүнийг эмч нарын хамтарсан зөвлөгөөнд оруулах үед энэ **“Өврийн лавлах”**-ыг авч ирэх ба эмч нараас зөвлөгөө авах нь чухал юм.



## Хавьтлын үзлэг шинжилгээнд хамрагдсан үед тэмдэглэх

This image shows a full page of white paper with horizontal dashed lines, typical of primary school writing paper. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.





## ЦАХИМ ХАЯГ:

[www.nccd.gov.mn](http://www.nccd.gov.mn)

[www.tubis.mn](http://www.tubis.mn)

[www.moh.mn](http://www.moh.mn)

[www.aids.mn](http://www.aids.mn)

[www.healthinfo.mn](http://www.healthinfo.mn)